



НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 4/476

Улаанбаатар хот

Г Нийслэлийн ерөнхий боловсролын  
21 дүгээр сургуулийн эргэлтийн бус  
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 9,739,098 (есөн сая долоон зуун гучин есөн мянга ерэн найм) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурх бичгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 21 дүгээр сургууль (Ц.Жаргалантуул)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй нийт 9,739,098 (есөн сая долоон зуун гучин есөн мянга ерэн найм) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий ном, сурх бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 21 дүгээр сургууль (Ц.Жаргалантуул)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

М.БАЯРАА



115050001283



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарын 2021 оны 12 дугаар сарын 06 -ны өдрийн А/476 дугаар тушаалын хавсралт

**Данснаас хасах хөрөнгийн эд хөрөнгийн жагсаалт**